



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 8/138

Мандалговь

Г Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг  
мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигийн хавсралтаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Дарга:

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүдэд:

Цэргийн штабын дарга

Онцгой байдлын газрын дарга

Тагнуулын хэлтсийн дарга

Цагдаагийн газрын дарга

Татварын хэлтсийн дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Статистикийн хэлтсийн дарга

Хоёр. Үндэсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулж, чиг үүргээр хангаж ажиллахыг нарийн бичгийн дарга (Б.Түвшинбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



438190388